

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн боловсролын асуудал хариуцсан арга зүйч, мэргэжилтэн / ЕБС / , Батмөнх Нямсүрэн

2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.1. БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН ХОЛБОГДОХ МЭРГЭЖИЛТНҮҮДИЙГ ЧАДАВХЖУУЛАХ ЗАМААР ЯЛГААТАЙ ХЭРЭГЦЭЭТЭЙ СУРАЛЦАГЧДЫН БОЛОВСРОЛД ХАМРАГДАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ							
1	Аймаг, дүүргийн боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл, ерөнхий боловсролын сургуулийн дэмжлэгийн багт арга зүйн дэмжлэг үзүүлэх замаар ялгаатай хэрэгцээтэй суралцагчийн боловсролд хамрагдалтыг нэмэгдүүлнэ.	ЕБС-д хамрагдалтыг нэмэгдүүлсэн хувь	1.4	0.5	"Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих" (EQUAL) төслийн хүрээнд Архангай, Сэлэнгэ, Сүхбаатар, Увс аймаг, Сүхбаатар, Хан – Уул, Баянзүрх дүүргийн Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл, ерөнхий боловсролын сургуулийн дэмжлэгийн багийн гишүүд багш, ажилтан албан хаагчдад зориулсан чадавхжуулах сургалтыг 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөс 09-ний өдрүүдэд цахимаар зохион байгууллаа. Сургалтад Архангай, Сэлэнгэ, Сүхбаатар, Увс аймаг, Сүхбаатар, Хан – Уул, Баянзүрх дүүргийн боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн	3-р сар, 4-р сар, 6-р сар, 8-р сар, 10-р сар	100%

					төлөөлөл, ерөнхий боловсролын 18 сургуулийн дэмжлэгийн багийн гишүүд, хүүхдийн хөгжлийг дэмжих танхимын багш, бусад багш ажилтан албан хаагчдын 301 төлөөллийг хамруулав. 2024-2025 оны хичээлийн жилд ЕБС 6273 ялгаатай хэрэгцээтэй суралцагч суралцаж байна. Боловсролын салбарын мэдээллийн системд 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар ХБ-тэй 6830 буюу 8.7%-иар өссөн үзүүлэлттэй байна. Бүх түвшний боловсролын сургалтын байгууллагад нийт 10.555 ХБ-тэй суралцагч хамрагдаж байгаа бөгөөд өсөлтийн хувийг өмнөх оны үзүүлэлттэй харьцуулан харвал 124 буюу 1.18% -иар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Хавсралт: 5 файл		
2	Аймаг, дүүргийн боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулж, ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг боловсролын үйлчилгээнд хүртээмжтэй хамруулах, анги дэвшин суралцахад дэмжлэг үзүүлэх ажлын удирдамжийг боловсруулан аймаг, нийслэлийн Боловсролын газарт хүргүүлж, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллана.	- Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо	-	1	1. Боловсролын мэдээллийн удирдлагын системд нөхөн бүртгэл хийлгэх хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын мэдээлэл Хөвсгөл аймгийн Мөрөн сумын "Ирээдүй XXI зуун" сургуулийн 2 суралцагч, Говь-Алтай аймгийн Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 1 суралцагч, Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын ерөнхий боловсролын сургуулийн 1 суралцагч, Сүхбаатар дүүргийн Нийслэлийн	3-р сар, 4-р сар, 6-р сар, 8-р сар, 10-р сар, 11-р сар	100%

				ерөнхий боловсролын 25 дугаар сургуулийн 2 суралцагч, Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн 1 суралцагч, Нийслэлийн ерөнхий боловсролын 55 дугаар сургуулийн 1 суралцагч нийт 8 суралцагч байна. Ердийн хэв шинжтэй ерөнхий боловсролын сургуульд хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид нь бэрхшээлийн төрөл, хэлбэр, хүндрэлийн түвшин зэргээс хамаарч богино болон урт хугацааны эмчилгээнд хамрагдаж буй суралцагчид нь эрүүл мэндийн шалтгааны улмаас хичээлээс завсардаж, хоцрогдол үүсэж байна. Боловсролын ерөнхий хуулийн 10.1.9 дэх “Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч нь бусад суралцагчийн адил боловсролын эзэмших тэгш боломж, нөхцөлөөр хангах”, 20.13. дахь заалт “Ерөнхий боловсролын сургууль нь сургууль завсардсан хүүхэд, насанд хүрэгчдэд ерөнхий боловсролыг Боловсролын ерөнхий хуулийн 8.1-д заасан хэлбэрээр нөхөн эзэмшүүлэх, сургуулийн насны хүүхдийг сургуульд үргэлжлүүлэн суралцахад дэмжлэг үзүүлнэ” гэж заасны дагуу албан байгууллагуудаас ирүүлсэн суралцагчдын материалыг цахим шилжилт,	
--	--	--	--	---	--

					нэгдсэн статистикийн газарт дотоод албан бичгээр суралцагчдын мэдээлэл, хурлын тэмдэглэл, холбогдох материалыг хүргүүлэв. 2. Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг боловсролын үйлчилгээнд хүртээмжтэй хамруулах, анги дэвшин суралцахад дэмжлэг үзүүлэх ажлын чиглэлээр сургуулийн өмнөх боловсролын 5, 6 настай 1060, ерөнхий боловсролын сургуулийн 5, 9, 12 дугаар ангийн 1572 нийт 2632 хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн судалгааг нэгтгэж, удирдамжийн төсөл болон тайлангийн загварыг боловсруулсан. Хавсралт: 6 файл		
1.2. ЯЛГААТАЙ ХЭРЭГЦЭЭТЭЙ СУРАЛЦАГЧТАЙ АЖИЛЛАЖ БУЙ БАГШ, ЭЦЭГ ЭХ, МЭРГЭЖИЛТНҮҮДИЙГ МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТАД ХАМРУУЛАХ, ЗӨВЛӨН ТУСЛАХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ							
3	Боловсролын байгууллагын багш нарыг тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр арга зүйн сургалтад хамруулна.	- Сургалтад хамрагдсан багшийн тоо	3930	1560	1.Нийслэлийн Монгол – Оросын хамтарсан сургуулийн удирдлага, багш нарт ТХБ-ын арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтыг 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан. Сургалтад багш, удирдах ажилтан, нийт 114 албан хаагч хамрагдсан. 2.НЕБ-ын “Эрдмийн өргөө” сургуулийн удирдлага, хамт олны хүсэлтээр арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтыг 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулав. Сургалтад удирдлага,	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	50%

					багш нарын төлөөлөл 160 хүн оролцсон. 3. БГД-ийн боловсролын хэлтсийн хүсэлтээр арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтыг 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулав. Сургалтад тус дүүргийн физикийн судлагдахууны 50 багш хамрагдлаа. 4.ЕБС-ийн багш, ажилтан, суралцагчдын ХБ-ийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, ХБ-тэй суралцагчдын хэрэгцээ, шаардлагад нийцсэн багц сургалтыг НЕБ-ын 21, 130 дугаар сургуулиудад 2025 оны 04 дүгээр сарын 03,17-ны өдрүүдэд зохион байгуулсан нийт 129 багш, ажилтан хамрагдсан. 5.“Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” төслийн мэргэжлийн бүлгийн сайн туршлага хуваалцах, боловсролын болон дэмжих үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий сургуулиудын үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах уулзалтыг 2025 оны 1 дүгээр сарын 29, 30-ны өдрүүдэд зохион байгуулав. Уулзалтад төслийн зорилтот сургуулиудын багш нар 125 оролцогч хамрагдсан. 6. Ховд аймгийн СӨБ, ЕБС-ийн эмч нарыг УБ хотод туршлага судлах, сургалтад 2025 оны 03 сарын 25 өдөр Хөгжлийн ялгаатай хэрэгцээтэй хүүхдэд дэмжлэг	
--	--	--	--	--	--	--

					үзүүлэх сэдвээр онол арга зүйн сургалтыг зохион байгуулсан. 7.ТХБ-ын цахим сургалтын платформ бий болох төслийн хүрээнд 21 аймгийн Боловсролын газар, 9 дүүргийн Боловсролын хэлтсийн ТХБ-ын асуудал хариуцсан мэргэжилтэн, зорилтот ЕБС-ийн удирдлага, багш нарын төлөөлөл нийт 100 албан хаагч хамрагдав. 8.ХБХХЕГ-тай хамтран Дундговь аймгийн СӨБ,ЕБС захирал, эрхлэгч, дэмжлэгийн багийн гишүүдэд 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр "Боловсролд тэгш хамруулах нь" сургалтыг зохион байгуулж, сайн туршлагын жишээг 30 албан хаагчид хуваалцсан. Хавсралт: 16 файл		
4	Ялгаатай хэрэгцээтэй суралцагчтай ажиллаж буй сургалтын байгууллагын удирдлага багш ажилтан, мэргэжилтнүүдэд зөвлөн туслах ажлыг зохион байгуулна.	- Зөвлөн туслах үйл ажиллагаанд хамрагдсан хүний тоо	702	100	1. GPE - төслийн хүрээнд 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдөр 10:00 - 12:00 цагийн хооронд цахим сургалтыг зохион байгуулсан. Сургалтад Аймгийн Боловсролын газар, дүүргийн Боловсролын хэлтсийн тэгш хамруулах боловсролын асуудал хариуцсан мэргэжилтэн, төслийн зорилтот ерөнхий боловсролын 18 сургуулиудын удирдлага, мэргэжлийн бүлгийн багш, хүүхдийн хөгжлийн дэмжих танхимын багш, боловсролын болон дэмжих үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий ерөнхий	3-р сар, 4-р сар, 5-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	100%

					боловсролын сургуулийн 30 төлөөлөл хамрагдсан. 2. “Ерөнхий боловсролын сургуулийн багш нарт зориулсан тэгш хамруулах боловсролын цахим сургалтын платформ бий болгох төсөл”-ийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн модулийн платформыг танилцуулах, цаашид түгээн дэлгэрүүлэх төлөвлөгөөг хэлэлцэх цахим уулзалтыг 21 аймаг, 9 дүүргийн зорилтот 30 сургуулийг хамруулан 2025 оны 04 сарын 04 өдөр зохион байгуулав. Сургалтад 21 аймгийн Боловсролын газар, 9 дүүргийн Боловсролын хэлтсийн дарга, Тэгш хамруулах боловсролын асуудал хариуцсан мэргэжилтэн, зорилтот ерөнхий боловсролын сургуулийн удирдлага, багш нарын төлөөлөл нийт 100 албан хаагч хамрагдав. Хавсралт: 5 файл		
5	Ялгаатай хэрэгцээтэй суралцагчийг боловсролын үйлчилгээнд тэгш, хүртээмжтэй хамруулах чиглэлээр төр, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллана.	- Хамтран ажилласан байгууллагын тоо	5	1	- "Ээлтэй ертөнц" төрийн бус байгууллагаас бүтээгдэхүүн, үйлчилгээ бүхий "Бүтээлч ирээдүй" төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах хүсэлт ирүүлсэний дагуу GPE төслийн Нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтын мэдээллийг мэйл болон утсаар мэдэгдсэн. - "Тэгш боломжийг бүрдүүлэх	2-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар	100%

					замаар суралцахуйг дэмжих төсөл"-ийн хүрээнд хэрэгжүүлж буй "Хөгжлийн бэрхшээлтэй үе тэнгийн найзуудаа дэмжих чиглэлээр нийт суралцагчдын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх" нөлөөллийн ажлыг зохион байгуулах талуудын уулзалтад оролцсон. Уулзалтад Боловсролын яам, БЕГ, төслийн нэгж, 5 төрийн бус байгууллагын төлөөллүүд хамрагдсан. Хавсралт: 9 файл		
6	Ялгаатай хэрэгцээтэй суралцагчтай ажиллаж буй багш нарыг интернэт болон БМТТ-ийн medle.mn цахим платформоор дамжуулан, суралцах, хөгжих боломжийг нэмэгдүүлнэ.	- Цахимд байршуулсан модулийн тоо, хамрагдсан багшийн тоо	3	4, 90	Адина-тэгш боломж” ТББ нь 2024 оны 1 дүгээр сараас эхлэн Боловсрол яам, Люксембургийн их вант улсын Гадаад хэргийн яамны санхүүжилтээр Монгол улсын ерөнхий боловсролын сургуулийн багш нарт зориулсан “Тэгш хамран сургах боловсролын онлайн сургалтын платформ бий болгох” төслийг ПАДЕМ Олон Улсын байгууллага, Боловсролын ерөнхий газартай хамтран хэрэгжүүлж эхлээд байна. Уг төсөл нь Ерөнхий боловсролын сургуулиудад суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах зорилготой хоёр жилийн хугацаанд Улаанбаатар хотын 9 дүүрэг болон 21 аймаг, зорилтот 30 сургуулийн хүрээнд уг төслийг хэрэгжүүлэн ажиллаж	3-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

				байна. Ерөнхий боловсролын сургуульд суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах зорилготой хоёр жилийн хугацаанд Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймгийн зорилтот 30 сургуулийг хамруулан уг төслийг Адина ТББ-тай хамтран 2024 оноос хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд: - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн 9 модулийг "Аутизм, Анхаарлын дутмагшил хэт хөдөлгөөнтөх эмгэг, Дауны хам шинж, Хэл яриа, Хөдөлгөөн, Хараа, Сонсгол, Суралцахуйн бэрхшээл, Оюун ухаан" бэрхшээлийн төрлөөр боловсруулан онлайн сургалтын платформд байршуулсан. - Арга зүйн 9 модулийг зорилтот 30 сургуулийн 90 багшийн дунд турших, сайжруулах, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаа зохион байгуулсан. - 2024-2025 оны хичээлийн жилд 60 сургагч багшийг бэлтгэн, нийт 302 багш, мэргэжилтэн, эцэг эх, асран хамгаалагч болон суралцагчидтай хамтран ажилласан. - Арга зүйн модулийн платформыг танилцуулах, цаашид түгээн дэлгэрүүлэх төлөвлөгөөг хэлэлцэх цахим уулзалтыг аймаг, нийслэлийн боловсролын газар, хэлтсийн удирдлагууд	
--	--	--	--	--	--

					болон зорилтот 30 сургуулийн нийт 100 албан хаагчид зохион байгуулсан. - Тэгш хамруулах боловсролтой холбоотой зарим нэр, томъёог гадаад хэлнээс монгол хэлнээ орчуулах талаар хэлэлцэх уулзалт 2 удаа зохион байгуулдаж нийт 34 оролцогч оролцож, санал бодлоо солилцсон. Хавсралт: 4 файл		
7	Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчдыг чадавхжуулах замаар тэдний оролцоонд түшиглэсэн сургалт зохион байгуулна.	-Сургалтад хамрагдсан эцэг эх, асран хамгаалагчдын тоо - нэмэгдүүлсэн хувь	167, 3.4	84, 1.4	1. “Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” GPE төслөөс хэрэгжүүлсэн “МИНИЙ НАЙЗ-БИДНИЙ НАЙЗ” нөлөөллийн үйл ажиллагааг Хан-Уул дүүргийн НЕБ-ын 15, 118, Баянзүрх дүүргийн НЕБ-ын 88 дугаар сургуулийн бага, дунд, ахлах ангийн сурагчдын дунд ХБ-тэй найзыгаа ойлгох, дэмжих, тэгш хамруулах соёлыг түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн нөлөөллийн ажлын 2025 оны 04 дүгээр сарын 21-25-ны өдрүүдэд зохион байгуулсан. Бага ангийн 524 суралцагч, дунд ангийн 329 суралцагч, ахлах ангийн 199 суралцагч нийт 1052 суралцагч үүнээс хөгжлийн бэрхшээлтэй-17 суралцагч, тэдний эцэг эх, асран хамгаалагчид оролцсон. ХБ-тэй суралцагчид урлагийн 9 номерыг (дуу, шүлэг, бүжиг) өдөрлөгт оролцогчдод тоглож үзүүлсэн. Бүх оролцогчид “Бид сайн найзууд” бүтээлийн	3-р сар, 4-р сар, 6-р сар, 10-р сар	100%

				үзэсгэлэнг бэлэн болгосноор тухайн хийж, бүтээсэн бүтээлийг сургуулийн “Хүүхэд хөгжлийн танхим”-даа бэлэглэж, хананд нь дурсгал болгон үлдээсэн. Бага ангийн өдөрлөгт оролцсон нийт 524 суралцагч, идэвхтэй зохион байгуулсан 52 багш, 5 эцэг эх, асран хамгаалагчид тус бүрд ТАЛАРХАЛ гардуулсан. 2.Нийслэлийн ерөнхий боловсролын 63, 92-р сургуулийн хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын эцэг эх, асран хамгаалагчидтай 2025 оны 05 дугаар сарын 12-13 өдрүүдэд фокус бүлгийн ярилцлага зохион байгуулж, хүүхдийн хөгжлийн талаар болон анги бүлэг дүүргэлт, сургалтын орчин, сургуулийн гадна болон дотор орчны хүртээмж туслах хэрэгсэл, тохируулагт хэрэглэгдэхүүн зэрэг тулгамдаж буй асуудал бэрхшээл, түүнийг шийдвэрлэх арга замыг хэлэлцсэн. Нийт 24 эцэг эх, асран хамгаалагчдын төлөөлөл оролцож санал бодлоо солилцсон. 3.Монголын Аутизмын Холбоо ТББ-аас Аутизмыг Таниулах Дэлхийн Өдөр зохион байгуулсан "Autism Fair 2025" Мэдээллийн яармагт "Тэгш хамруулах боловсролын бодлогын хэрэгжилт" сэдэвт илтгэлийг танилцуулж, багш, эцэг эхчүүдэд шаардлага, хэрэгцээтэй мэдээллийн эх	
--	--	--	--	--	--

					сурвалжуудтай танилцах талаарх мэдээллийг хүргэсэн. Өдөрлөг 500 орчим иргэд хамрагдсан байна. Хавсралт: 3 файл		
8	Эцэг эх, олон нийтэд тэгш хамруулах боловсролын чиглэлээр эерэг хандлагыг бий болгох зурагт хуудсыг бэлтгэн түгээн дэлгэрүүлэх, нөлөөллийн ажлыг зохион байгуулна. (зурагт хуудас эсвэл бичлэг)	- Зурагт хуудас эсвэл бичлэгийн тоо	-	2	1.Тэгш хамруулах боловсролын чиглэлээр хэрэгжсэн төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд боловсруулагдсан ном, гарын авлага, зөвлөмжүүдийг цахим хэлбэрээр хүргэсэн. Тус гарын авлага, зөвлөмжүүдийг ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллаж буй бүх түвшний сургалтын байгууллагын удирдлага, багш, ажилчид, эцэг эх, асран хамгаалагчид дараах линкээр хандан татаж авч ашиглах бүрэн боломжтой. 574 хүн хуваалцсан. 2.ЖАЙКА "Тэгш хамрах сургах боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл" II шат (СТАРТ2 төсөл)- ны хүрээнд багш нарт зориулан боловсруулсан видео контентыг нэгтгэн хүргэсэн. 374 хүн хуваалцсан. 3. “МЭРГЭЖЛЭЭ ЗӨВ СОНГОЁ” аяны хүрээнд “ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ БОЛОВСРОЛЫН БАГШ”-ийг танилцуулж байна. #Цуврал 2 Тусгай хэрэгцээт боловсролын багш гэж хэн бэ?. Тусгай хэрэгцээт боловсролын багшийг	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	100%

					хаана бэлтгэдэг вэ? Тусгай хэрэгцээт боловсролын багшаар элсэхэд ямар шалгалт өгөх вэ? Дээрх мэдээллүүдийг бэлтгэн багш, эцэг эх, олон нийтэд түгээн дэлгэрүүлсэн. Хавсралт: 7 файл		
9	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсрол эзэмшихэд дэмжих төвийн загварыг туршилтаар хэрэгжүүлнэ.	- Мэргэжил арга зүйн зөвлөгөө үзүүлсэн албан хаагч, иргэний тоо	40	40	Боловсролын ерөнхий газар, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, Боловсролын үнэлгээний төв, Нийслэлийн боловсролын газар, Нийслэлийн 186 дугаар цэцэрлэг, Нийслэлийн ерөнхий боловсролын 25 дугаар сургууль, Нийслэлийн ерөнхий боловсролын 55 дугаар сургууль, Нийслэлийн ерөнхий боловсролын 70 дугаар сургууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн төлөөлөл хамтран сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн насны хавсарсан, хүнд хэлбэрийн, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд боловсролын үйлчилгээ үзүүлж буй дараах дэмжих төвүүдийн албан хаагчдад арга зүйн дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах үйл ажиллагааг 2025 оны 02 дугаар сарын 21, 26-нд Ээлтэй ертөнц ТББ 13, Энэрэлийн түүчээ ТББ 12, Эрхэм нандин сувд ТББ 7, Аутизмд хийсэн аялал ТББ 11,	2-р сар, 4-р сар, 5-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	100%

					нийт 4 ТББ-ын 43 албан хаагчдад арга зүйн дэмжлэг үзүүлж, зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулсан. Энэхүү үйл ажиллагааг туршилтаар хэрэгжүүлснээр Боловсролын сайд, Эрүүл мэндийн сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/85, А/55, А/49 дүгээр хамтарсан тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий дэмжих төвийн дүрэм” батлагдсан. Хавсралт: 2 файл		
10	Брайл үсгээр шинээр хэвлэгдэх I-V ангийн сурах бичгийн захиалгыг авч холбогдох газарт хүргүүлнэ.	- Гүйцэтгэлийн хувь	-	25	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 176 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал (2024-2036)”-ыг баталсан. Үүнтэй холбоотойгоор Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгээс сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах, туршин сайжруулах, хэрэгжүүлэх ажлыг 2024-2025 оны хичээлийн жилд зохион байгуулж байна. Тус хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд боловсруулагдсан сурах бичгийг Боловсролын ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.9	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар	100%

					дэх хэсэгт тусгасны дагуу харааны бэрхшээлтэй суралцагчид зориулан брайл бичигт хөрвүүлэх сурах бичгийн тоон мэдээллийг гаргаж, харааны бэрхшээлтэй суралцагчдад хэрэгцээтэй сурах бичгийн судалгааг авч нэгтгэн ажилласан. 21 аймгийн хэмжээнд том тод үсэгтэй сурах бичиг 28, брайл сурах бичиг 45, хосолсон сурах бичиг 8 ширхэг хэрэгцээ шаардлагатай байна. 9 дүүргийн хэмжээнд том тод үсэгтэй сурах бичиг 79, брайл сурах бичиг 52, хосолсон сурах бичиг 7 ширхэг хэрэгцээ шаардлагатай байна. Хавсралт: 2 файл		
3.1. НЭГЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ МӨРДӨН АЖИЛЛАЖ, БАЙГУУЛЛАГЫН ӨДӨР ТУТМЫН ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХ							
11	Ерөнхий газрын даргын шуурхай хурал, даргын зөвлөлийн хурал, Суралцагчийн хөгжлийн газрын шуурхай хурал, Тэгш хамруулах хэлтсийн шуурхай хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллана.	- Үүрэг даалгаврын биелэлтийн хувь	100%	100%	Ерөнхий газрын даргын шуурхай хурал, даргын зөвлөлийн хурал, Суралцагчийн хөгжлийн газрын шуурхай хурал, Тэгш хамруулах хэлтсийн шуурхай хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган ажилласан. Хавсралт: 6 файл	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
---	-----------------	---------------	---------

1	2	3	4
---	---	---	---

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Тэгш хамруулах боловсролын хүрээнд арга зүйн чиглэлээр гадаад, дотоодод, урт, богино хугацааны сургалтад хамрагдана.	- Хамрагдсан сургалтын тоо	-	2	1. "Урлаг хөгжлийн төлөө" урлагийн боловсрол олгох 3-модуль сургалтад 2025 оны 02 дугаар сарын 5-6 өдрүүдэд гарын авлага танилцуулах, төслийн сайн туршлагыг хуваалцах сургалтад хамрагдсан. 2. Боловсрол дэлхийн түншлэл GPE олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжүүлж буй "Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төслийн хүрээнд Боловсролын яам, харьяа байгууллагын албан хаагч нарт зориулсан нарт зориулсан "Монгол дохионы хэлний харилцааны анхан шат"-ны мэдлэг олгох 30 цагийн сургалтад 2025 оны 04 дүгээр сарын 28-наас 05 дугаар сарын 02-ны өдрүүдэд амжилттай хамрагдаж батламж авсан. Хавсралт: 7 файл	4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

2	Боловсролын яам, Боловсролын ерөнхий газар болон холбогдох дээд шатны байгууллагаас зохион байгуулсан үйл ажиллагаанд хамрагдана.	- Хамрагдсан арга хэмжээний тоо	-	3	1.Боловсролын яамнаас 2025 оны 02 сарын 10-ны өдөр зохион байгуулагдсан “Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааны журмын мэдээлэл, танилцуулгад оролцсон. 2. Боловсролын яамнаас 2025 оны 04 сарын 16-ны өдөр зохион байгуулагдсан "Боловсролын салбарын өгөгдлийн шинжилгээний дашбоардыг тайлбарлах ашиглах сургалтад хамрагдсан. 3. Боловсролын яамнаас 2025 оны 05 сарын 26-ны өдөр зохион байгуулагдсан “Эрүүл-аюулгүй сургууль” арга хэмжээний төлөвлөгөө хэрэгжүүлэхэд оролцогч талуудын оролцоог хангах, нэгдсэн ойлголтод хүрэх, хамтран ажиллах боломжийг тодорхойлох уулзалтад оролцсон. Хавсралт: 10 файл	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
---	--	--	---	---	---	---	------

ТАЙЛАН ГАРГАСАН:

Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн боловсролын асуудал хариуцсан арга зүйч, мэргэжилтэн / ЕБС /, Батмөнх Нямсүрэн
/...../ Огноо: